

ЧӨЛӨӨТ БҮС ЭРХ ЗҮЙН ТУСГАЙ ДЭГЛЭМ БҮХИЙ НУТАГ ДЭВСГЭР БОЛОХ НЬ (БНСУ, БНХАУ, ОХУ-ын жишээн дээр)

A FREE ZONE AS A SPECIAL LEGAL REGIME TERRITORY (Based on the Cases of South Korea, China, and Russia)

Б.Доржханд
Шихихутуг Их сургууль магистрант

Товч агуулга: Дэлхийн зарим улс орнууд нутаг дэвсгэрийнхээ газарзүйн байршлын давуу талаа ашиглан чөлөөт бүс байгуулж, дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдад ашигтай байршил, үйл ажиллагаа явуулах дэд бүтэц, татварын хөнгөлөлт, тусгай зохицуулалтын орчныг санал болгох замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, улс орны өрсөлдөхүйц чадварыг хөгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурал “Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай үзэл баримтлалыг 1995 онд баталж, 2002 онд “Чөлөөт бүсийн тухай”, “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай”, 2003 онд “Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай”, “Цагааннуур худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хуулиудыг батлан гаргасан байна. Монгол Улсын Их Хурлын тогтоолоор дөрвөн чөлөөт бүсийг байгуулсан бөгөөд одоог хүртэл үйл ажиллагаагаа бүрэн явуулж эхлээгүй, тухайн бүсийн дэд бүтцийг цогцоор нь бүрэн шийдвэрлээгүйгээс хөрөнгө оруулалтууд саатсан, эрсдэл хүлээхээс айсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн хилийн байгууллагын хамгаалалтад байдаг тал газар хэвээр байна.

Иймээс чөлөөт бүс бүрэн утгаараа хөгжиж буй БНСУ, БНХАУ, ОХУ-ын чөлөөт бүсийн газар зүйн байрлал, удирдлагын тогтолцоо, гааль татварын бодлого, хөрөнгө оруулалт татсан туршлага, эрх зүйн орчны ялгаа, төрийн зохицуулалт, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг харьцуулан судалж, Монгол Улсад тохирох загварыг тодорхойлохыг зорьсон.

Abstract: Some countries in the world are using the advantages of their geographical location to establish free zones and offer domestic and foreign investors a profitable location, infrastructure for operating, tax breaks, and a special regulatory environment, thereby increasing economic growth and developing the country's competitiveness.

The Mongolian State Great Khural approved the “Concept of Establishing Free Economic Zones” in 1995, and in 2002, the laws “On Free Zones”, “On the Legal Status of the Altanbulag Free Trade Zone”, “On the Legal Status of the Zamyn-Uud Free Economic Zone”, and “On the Legal Status of the Tsagaannuur Free Trade Zone” were adopted. Four free zones were established by the resolution of the Mongolian State Great Khural, and they have not yet fully started operating and the infrastructure of the zones has not been fully resolved, so investments have been delayed and citizens and businesses are still under the protection of border agencies for citizens and businesses who are afraid to take risks.

Therefore, the aim was to compare the geographical location, management system, customs and tax policies, investment attraction experience, legal environment differences, state regulation, and investment support policies of the free zones of the Republic of Korea, the People's Republic of China, and the Russian Federation, where free zones are developing in the full sense of the word, and to identify a model suitable for Mongolia.

Түлхүүр үг: Эдийн засгийн чөлөөт бүс, чөлөөт бүс, нутаг дэвсгэр, хөрөнгө оруулалт, Инчон, Шанхай, Иннополис.

Keywords: Free economic zone, free zone, territory, investment, Incheon, Shanghai, Innopolis.

Удиртгал

Анхны чөлөөт бүсийг 1959 онд Ирландад Шанноны экспортын чөлөөт бүс хэмээн байгуулсан бөгөөд түүнээс хойш дэлхий даяар нийт 135 оронд 3500 гаруй бүс байгуулагдсан байна.

Япон Улсын Киото хотноо 1973 онд “Гаалийн бүрдүүлэлтийг нэг мөр болгох тухай” Олон улсын конвенц батлагдан уг конвенцод “Чөлөөт бүс нь нэг улсын нутаг дэвсгэрийн тодорхой нэг хэсэг бөгөөд тэнд оруулсан бараа, бүтээгдэхүүн нь тухайн улсын нутаг дэвсгэрийн гадна байгаа гэж тооцогдож импортын татвар, гаалийн энгийн шалгалтаас чөлөөлөгдөнө”¹ гэж заасан.

Монгол Улсад “Чөлөөт бүс” гэж дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдыг татах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэмийн хүрээнд гаалийн болон бусад татварыг хөнгөвчилж экспортыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох Монгол Улсын нутаг дэвсгэрийг хэлнэ.

УИХ-ын 1995 оны 87 дугаар тогтоолоор Монгол Улсад Чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал батлагдсан.² Чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зорилгыг “тус улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байрлал, зам харилцааны боломжийг зохистой ашиглан, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэт технологи оруулах замаар эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон. Энэхүү зорилгын хүрээнд “Чөлөөт бүсэд гадаадын хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцөл бүрдүүлж, дотоодын аж ахуйн нэгжүүдийг тэдгээртэй эдийн засгийн ижил орчинд өрсөлдөх нөхцөлөөр хангах”, мөн угтвар нөхцөлд “Чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, чөлөөт бүсийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгж, байгууллага чөлөөтэй, итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин нөхцөл бий болгох”, “гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц нөхцөл бүрдсэн байх” гэсэн арга хэмжээг авахаар заажээ.

Чөлөөт бүсийг газар зүйн хувьд оновчтой байршилд байгуулан гадаад худалдааны эргэлтийг сайжруулах, экспортыг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар тухайн улс эдийн засгийн олон талын үр ашгийг хүртдэг. Чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлж чадсан улсуудын ихэнх нь далайн боомт болон бусад улстай хил залгаа эдийн засгийн ач холбогдолтой цэгийг сонгон байгуулсан байна.

Монгол Улс газар зүйн байрлалын хувьд хоёр улстай хиллэдэг, далайд гарцгүй зэрэг онцлог нутаг дэвсгэртэй бөгөөд одоогийн байдлаар Монгол Улсын Их Хурлаас нийт дөрвөн чөлөөт бүсийг байгуулахаар тогтоосон. Чөлөөт бүсийн эдийн засгийн үр нөлөөг гаргахын тулд хөгжиж буй улс орнууд тэр дундаа хөрш орнуудын туршлагаас судлах шаардлага зайлшгүй байна.

Нэг. БНСУ-ын Инчоны эдийн засгийн чөлөөт бүс

БНСУ нь үндэсний өрсөлдөх чадварыг сайжруулах, гадаадын иргэдийн амьдрах нөхцөлийг хангах, дэлхийн жишигт нийцсэн дэд бүтцийг санал болгох замаар гадаадын бизнес эрхлэгчдийг татах, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих үүднээс анхны эдийн засгийн чөлөөт бүсийг Инчонд 2003 оны 08 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан. Инчоны эдийн засгийн чөлөөт бүс нь БНСУ-ын хамгийн том, стратегийн ач холбогдол бүхий бүсүүдийн нэг юм. Түүнээс хойш 9 эдийн засгийн чөлөөт бүсийг орон нутгийн онцлог бүрд

¹ Гаалийн бүрдүүлэлтийг нэг мөр болгох тухай конвенц 1973 онд батлагдсан, Монгол Улс 2006 онд нэгдэн орсон.

² Монгол Улсад Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал УИХ-ын 1995 оны 87 дугаар тогтоолын хавсралт

нь тохируулан хөгжүүлж байна. Эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлснээр хөрөнгө оруулалтыг татах, инновацын хөгжилд түлхэц үзүүлсэн. Тус улсын "Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль" нь гаднын хөрөнгө оруулагчдад ээлтэй нөхцөлийг бүрдүүлж, төрийн дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг агуулдаг.³

Инчоно эдийн засгийн чөлөөт бүсийг 2003-2030 он хүртэл хөгжүүлэхээр төлөвлөжээ. Тус бүс нутгийг Зүүн хойд Азийн төв болох стратегийн гол цэг гэж үздэг. Тус төслийн хөгжлийн бүсүүдэд Сонгдо (бизнес, мэдээллийн технологи), Ёонгжон (логистик, аялал жуулчлал), Чеонгна (бизнес-санхүү, аялал жуулчлал амралт, орчин үеийн технологийн аж үйлдвэрлэл) хотууд, Инчоно олон улсын нисэх онгоцны буудал, боомт зэрэг нийт 122,34 км квадрат талбайг хамардаг. Тус бүс нь дэлхийн хоёр дахь том эдийн засагтай БНХАУ, гурав дахь том эдийн засагтай Япон улс хоёрын дунд оршдог. Тус улсуудын төв хотууд руу Инчоно нисэх онгоцны буудлаас 3 цаг хүрэхгүй хугацаанд хүрэх боломжтой. Жишээлбэл, Шанхай, Бээжин хотууд руу 2 цаг, Токио, Хонконг хотууд руу 2 цаг 30 минут нисэж хүрнэ. Энэ нь газар зүйн байршлын хувьд нэн таатай, өрсөлдөх чадвар сайтай, эдийн засаг, аж үйлдвэрийн гол тэнхлэг болсноороо онцлогтой юм. Бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь 3 үе шаттай хэрэгжихээр төлөвлөгдсөн бөгөөд одоо 3 дахь үе шат буюу 2015-2030 он хүртэл хөгжлийн төслүүдийг дуусгах, эцэслэх төсөл хэрэгжиж байна. Сүүлийн 18 жилийн хугацаанд 400,000 гаруй оршин суугч, 3,300 аж ахуйн нэгж, GCF (Ногоон уур амьсгалын сан)-ийн олон улсын 14 байгууллага, гадаадын нэр хүндтэй их сургуулиудыг багтаасан дэлхийн хот болон хурдацтай хөгжиж байгаа талаар Инчоно эдийн засгийн чөлөөт бүсийн комиссар Юн Вон Сок мэндчилгээндээ дурджээ.⁴

Тус улсын төр, орон нутгийн захиргаанаас эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх зорилгод хүрэхийн тулд шаардлагатай дэмжлэгийг үзүүлдэг бөгөөд тус улсын Худалдаа, үйлдвэр, эрчим хүчний яамнаас бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг баталж, удирдлагын хяналт зохицуулалтыг төслийн гүйцэтгэгч буюу комиссар хариуцдаг.

Удирдлагуудад Аюулаас урьдчилан сэргийлэх, хянах хэлтэс, төлөвлөлт, зохицуулалтын төв, хөрөнгө оруулалт татах төв, Сонгдо, Ёнжон, Чоннагийн үйл ажиллагааны төвүүд хамаардаг.⁵ Тус улсын Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хуульд эдийн засгийн чөлөөт бүс нь шаардлагатай дэд бүтэц, мэдээлэл харилцаа холбооны сүлжээ, нийтийн тээврийн зохицуулалт хийгдсэн байх, бизнес эрхлэгчдийн, хөдөлмөр эрхлэгчдийн, аялал жуулчлалын таатай орчныг хангасан байх зэрэг шаардлагуудыг тавьдаг байна. Харин чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын төслийн гүйцэтгэгчийг гадаадын хөрөнгө оруулалтыг татах чадвар, санхүүгийн тогтвортой байдал, ижил төстэй бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлж байсан туршлага зэргийг харгалзан сонгож нийтэд мэдээлэх байдлаар томилдог.

Чөлөөт бүсийн дэд бүтэц, авто зам, холбооны байгууламжийг тухайн орон нутаг, дүүргийн захиргаа нь өөрийн зардлаар хийж гүйцэтгэдэг. Аж үйлдвэрийн цогцолборуудыг тус улсын Аж үйлдвэрийн газар, хөгжлийн тухай, Инновацын хотуудыг байгуулах, хөгжүүлэх тухай хуульд зааснаар тусгай шаардлагуудыг ханган хөгжүүлдэг. Гадаадын иргэдийн амьдрах нөхцөлийг хангах, аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт олгох замаар хөрөнгө оруулалтыг татдаг байна. Эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтын аливаа төслийг саадгүй хэрэгжүүлэхэд шаардлагатай бол төр, орон нутгийн засаг захиргаанаас аж ахуйн нэгжийн татвар, орлогын албан татвар, гаалийн татвар, худалдан авалтын албан татвар, бүртгэлийн татварыг бууруулах, чөлөөлөх зэрэг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлдэг. Мөн шаардлагатай бол тус улсын бусад хууль тогтоомжоор заасан төлбөр хураамжуудыг бууруулах, чөлөөлж болохоор зохицуулалтыг тусгасан байна. Жишээлбэл, тариалангийн талбайн хамгаалалтын төлбөр, замын түгжрэлийн төлбөр, нийтийн ус ашигласны төлбөр, экосистемийг хамгаалах төлбөрүүдийг бууруулах гэх мэт.

³ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=64578&lang=ENG

⁴ <https://www.ifez.go.kr/world/content/view.do?sn=616>

⁵ <https://www.ifez.go.kr/world/content/view.do?sn=623>

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрийн бүтээн байгуулалт эхлүүлэхэд, дэвшилтэт технологи, бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийдэг аж ахуйн нэгж, стратегийн гол салбаруудад хөрөнгө оруулалт хийж буй аж ахуйн нэгжүүдэд улсын болон орон нутгийн татварыг бууруулах, чөлөөлөх болон эмнэлэг, боловсрол, эрдэм шинжилгээний барилга байгууламж барих зэрэгт газрын түрээсийн төлбөрөөс хөнгөлөх зохицуулалтууд ч байдаг. Эдгээр татвар хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгосон бол тухайн орон нутгийн захиргаанд улсаас татаас олгодог байна.

Инչоны чөлөөт бүс нь БНСУ-ын Засгийн газрын бодлогын хүрээнд онцгой дэмжлэг авдаг бөгөөд хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд олон улсын стандарт бүхий дэд бүтэц, татварын хөнгөлөлтийг санал болгодог байна. Тус бүсийн зорилго нь өндөр технологи ашиглаж, хамгийн сүүлийн үеийн үйлдвэрлэлийн аргуудыг нэвтрүүлэх замаар эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулахад оршино. Энэ нь экспорт, инновац, технологийн шинэчлэлийн өндөр үзүүлэлтүүдийг гол стратеги болгож хөгжиж байгааг харуулж байна.

Хоёр. БНХАУ-ын Шанхайн чөлөөт худалдааны бүс

БНХАУ нь хамгийн өргөн хүрээнд чөлөөт бүсүүдийг хөгжүүлсэн улс бөгөөд "Шанхайн чөлөөт худалдааны бүс" нь олон улсын худалдааны шинэчлэл, либералчлалын туршилтын бүс болж хөгжсөн⁶. 2023 оны байдлаар БНХАУ-д 21 чөлөөт бүс ажиллаж, нийт 500 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан байна. Хятадын эрх зүйн зохицуулалт нь бүс нутгийн онцлогт тохируулан ялгаатай байдлаар хэрэгждэг бөгөөд Шэньжэнь, Шанхай зэрэг томоохон бүсүүд нь инновац, технологийн салбарт илүү анхаардаг⁷.

БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт COVID-19 цар тахлын дараа төсөөлж байснаас удаашралтай байгаа боловч Олон Улсын Валютын сангийн мэдээлснээр 2023 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад орж буй Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан ч дэлхийд дөрөвдүгээрт бичигдсэн хэвээр байна.⁸ Хятад улсын туршилтын бүсүүд нь улс орны стандартын шинэчлэл, нээлттэй байдлыг хангахад түлхэц болсон бөгөөд тус улсын гадаадын хөрөнгө оруулалт, экспорт импортын нийт хэмжээний 20 орчим хувийг бүрдүүлсэн. Тус бүсүүдийн гадаад худалдаа 2023 оны мөн үеийнхээс 11,99 хувиар тэлсэн бөгөөд экспорт импортын нийт хэмжээ 6,09 их наяд юань (ойролцоогоор 853,1 тэрбум ам.доллар) хүрсэн байна.⁹

БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс Шанхайн чөлөөт худалдааны бүсийг 2013 оны 8 дугаар сарын 22-ны өдөр хил дамнасан хөрөнгө оруулалт, худалдааг өргөжүүлэх зорилгоор байгуулахыг зөвшөөрч 9 дүгээр сарын 29-ний өдөр анхны чөлөөт худалдааны туршилтын бүс болгон албан ёсоор байгуулсан. Тус бүсэд далайн тээвэр, ложистик, худалдаа үйлчилгээ, барилга байгууламж, мэргэжлийн үйлчилгээ, соёл урлаг, үзвэр үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд зэрэг үйл ажиллагаанд хууль тогтоомжийн уян хатан байдлыг санал болгох замаар туршилтын бүсийг байгуулж, цаашид улс даяар нэвтрүүлэх бодлоготой байсан. 2019 онд 240,2 хавтгай дөрвөлжин километр талбайтай болж өргөжсөн бөгөөд тус бүсэд Вайгаочао чөлөөт худалдааны бүс, ложистикийн парк, Яншань худалдааны чөлөөт боомтын бүс, Пудун нисэх онгоцны буудал, Лузиаэзуй санхүүгийн дэд бүс, Жиньциао эдийн засаг, технологийн хөгжлийн бүс, Занжиань технологийн парк, экспогийн талбай, Лиганг шинэ бүсийг нэгтгэсэн байна.

Шанхайн чөлөөт худалдааны бүсийн гол зорилго нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, худалдааг хөнгөвчлөх, санхүүгийн шинэчлэлийг турших явдал юм. 2020 оны байдлаар тус бүсэд 12,000 гаруй аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 2,000 орчим нь гадаадын

⁶ Chinese Ministry of Commerce. (2023). Development of Free Trade Zones in China: Policies and Impact. Beijing: Commerce Press.

⁷ World Bank. (2023). The Role of Free Economic Zones in Global Trade and Investment. Washington, DC: World Bank Group.

⁸ <https://www.state.gov/reports/2024-investment-climate-statements/china/>

⁹ https://english.www.gov.cn/archive/statistics/202410/31/content_WS6722c222c6d0868f4e8ec750.html

хөрөнгө оруулалттай компаниуд байна. Нийт гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 12 тэрбум ам.долларт хүрсэн. Тус бүсийн үйл ажиллагааны үр дүнд 2020 онд гадаад худалдааны нийт эргэлт 1.5 их наяд юаньд хүрсэн нь Шанхайн нийт гадаад худалдааны 40 орчим хувийг эзэлж байна. Мөн санхүүгийн салбарт олон улсын төлбөр тооцооны юанийн хэрэглээ нэмэгдэж, 2020 онд 200 тэрбум юанийн гүйлгээ хийгдсэн.

Шанхайн чөлөөт худалдааны бүсийн удирдлагыг Сингапурын аж үйлдвэрийн бүсийн жишгээр төр, хувийн хэвшлийн хамтарсан зохицуулалтаар гүйцэтгэдэг. Шанхай хотын захиргааны удирдлага дор бодлогын хэрэгжилт, зохицуулалтыг гаалийн байгууллага хэрэгжүүлдэг. Тус чөлөөт бүсийн удирдах газар нь төр, хувийн хэвшлийн хоёр захиргаанд хуваагддаг. Захиргааны харьяа газруудад Захиргааны алба, Хүний нөөцийн газар, Эдийн засгийн хөгжлийн газар, Төсөв санхүүгийн үйлчилгээний газар, Төлөвлөлт, барилга, байгаль орчны газар, Хяналт шалгалт, хуулийн хэрэгжилтийн газар, Яншань чөлөөт худалдааны боомтын газар, Вайгаочао чөлөөт худалдааны бүсийн газар, Пудун нисэх онгоцны буудлын чөлөөт худалдааны газар хамаарна. Харьяа байгууллагуудын хувьд Шанхайн чөлөөт бүсийн баталгаат бүсийн хуулийн төв, Мэдээллийн төв, Бүсийн хот байгуулалт, менежментийн төв, хөрөнгө оруулалтын үйлчилгээний төвөөр дамжуулан удирдлагын үйл ажиллагааг явуулдаг байна.¹⁰

Дэлхийн жишигт нийцүүлэхийн тулд Шанхай хотыг хамгийн түрүүнд сонгосон нь Хятадын шинэчлэлийг эрчимжүүлэх, ололт амжилтыг Хятад улс даяар нэвтрүүлэх чухал алхам гэж үзсэн байна. Өдгөө 50,000 гаруй гишүүн компанитай, гадаадын хөрөнгө оруулагчдад илүү нээлттэй бөгөөд чөлөөт худалдааны дансыг ашиглах боломжийг зөвхөн Шанхайд санал болгодог. Гадаадын хөрөнгө оруулагчдад 45 зүйл заалт бүхий “Сөрөг жагсаалт”-д орсноос бусад үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулах боломжууд нээлттэй. “Сөрөг жагсаалт” гэдэг нь тус улсын хууль тогтоомжоор хориглосон болон чөлөөт худалдааны бүсэд гадаадын хөрөнгө оруулагч эрхлэхийг хориглосон үйл ажиллагааг хэлнэ. Жишээлбэл, галт зэвсэг үйлдвэрлэх. Шанхайн чөлөөт худалдааны бүсэд гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд бүртгэлийн шинэ системээр үүсгэн байгуулагдаж, ажлын 8 өдөр зарцуулдаг бүртгэлийн үйлчилгээг “нэг цонхны үйлчилгээ”-ээр хялбар шуурхай авч, төрийн байгууллагуудын бүртгэл, хяналт, татвар гэх мэт шаардлагатай мэдээлэл, бүртгэлийн үйлчилгээг 1 өдрийн дотор авдаг болсон.

Дэлхийн гаалийн байгууллагаас санаачилсан гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөх зорилгоор гаалийн бүрдүүлэлтийг өдөрт нь хийж, хяналтын давтамжийг багасгаснаар бараа бүтээгдэхүүнийг дараагийн өдөр худалдаанд гаргах боломжтой болдог. Шанхайн чөлөөт худалдааны бүс нь дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг татах, худалдааг дэмжих, инновацыг хөгжүүлэхэд чиглэсэн олон төрлийн татварын хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлдэг. Дэвшилтэт технологийн үйлдвэрлэл, боловсрол, судалгааны салбаруудын аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тогтоосон хувиас 15 хувиар бууруулах, чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, цахим худалдаанд татвар ногдуулахгүй, санхүүгийн үйлчилгээнд татварыг бууруулах, гадаад мэргэжилтний ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт эдлэх, биотехнологи, хиймэл оюун ухаанд суурилсан салбаруудыг татвараас чөлөөлөх зэрэг хөнгөлөлт чөлөөлөлтүүдийг санал болгодог.

Шанхайн чөлөөт худалдааны бүс нь БНХАУ-ын компаниудын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт хийх санхүүгийн төв болсноороо онцлог бөгөөд тус улсын эдийн засгийн өсөлт, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр чухал үүрэг гүйцэтгэж, бусад бүс нутагт ижил төстэй бүсүүдийг байгуулахад үлгэр жишээ болж байна.

Гурав. ОХУ-ын Иннополис эдийн засгийн тусгай бүс

¹⁰ <http://en-shftz.pudong.gov.cn/>

ОХУ Монгол Улсын хувьд стратегийн түнш гэдгээрээ асар их ач холбогдолтой орон юм. Тус улс нь Алс Дорнодын бүс нутагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор тусгай эдийн засгийн бүсүүдийг хөгжүүлж байна¹¹. 2005 онд Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль батлагдсан. Тус хуулиар бүс байгуулах, удирдах, гааль, татварын хөнгөлөлт, бусад механизмыг зохицуулсан. Тусгай бүс байгуулах санаачилгыг орон нутгийн захиргаанаас гаргаж, Засгийн газар зөвшөөрлийг олгодог. ОХУ 2006 онд “Оросын эдийн засгийн чөлөөт бүс ХК”-ийг байгуулж, чөлөөт бүсийн удирдлагын системийг бий болгосон. Тус компани нь 100 хувь улсын эзэмшлийн компани бөгөөд олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үйлчилгээ, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, технологийг бүсэд бий болгох, үйлдвэрлэлийн тэргүүний технологийг нэвтрүүлэх, нутагшуулах зорилготой. Тус компанийн тэргүүнийг Эдийн засаг хөгжлийн сайд томилдог. 2023 оны байдлаар ОХУ-д 40 гаруй чөлөөт бүс бүртгэгдсэн бөгөөд эдгээр бүсүүдэд нийт 70 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт оржээ¹². Үүнээс хамгийн отгон гэж хэлж болохоор Иннополис эдийн засгийн тусгай бүс нь 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр байгуулагдаж, 2015 онд албан ёсоор нээлтээ хийж байсан.

Иннополис эдийн засгийн бүс нь мэдээллийн технологи, инновац, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.¹³ Тус бүс нь Оросын Холбооны Улсын Казань хотоос 32 км-ийн зайд оршдог хамгийн залуу хот бөгөөд 7600 гаруй оршин суугчтай. Энэ бүсэд мэдээллийн технологийн салбарт мэргэжилтнүүдийг бэлтгэх, инновацыг дэмжих, технологийн компаниудыг татах зорилготой бөгөөд мэдээллийн технологи, дэвшилтэд технологийн төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх зүйл бий. Иннополис эдийн засгийн тусгай бүс нь технологийн компаниудын хөгжлийг дэмжих зорилгоор байгуулагдсан, мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн хүсдэг орон зай юм. Тус бүсийн хөгжлийн төлөвлөгөөг Сингапурын хотыг төлөвлөгч Дю Тай Кер бүтээжээ.¹⁴ 2018 оноос Жолоочгүй такси үйлчилгээ, 2020 оноос хүргэлтийн роботын үйлчилгээ, жолоочгүй нийтийн тээврийн төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа өндөр хөгжилтэй хотуудын нэг юм. 2024 онд робот зочид буудлын бүтээн байгуулалтыг эхэлсэн байна. Тус бүсэд оршин суугч болон гадаадын компаниуд татварын хөнгөлөлт эдлэхээс гадна олон улсын түвшний дэд бүтэцтэй, их сургуулийн хүртээмж, бүх төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой юм. Иннополис Их Сургуульд мэргэжилтнүүдийг мэдээллийн технологийн компаниудтай хамтран бэлтгэдэг. Мөн гадаад орнуудаас мэргэшсэн мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулж, шилжүүлэн ажиллуулдаг учир өндөр түвшинд мэргэшсэн мэргэжилтнүүдтэй ажиллахад давуу тал болдог.

Иннополис эдийн засгийн онцгой бүсийн компаниудын ажилтнууд Иннополисын нутаг дэвсгэрт орчин үеийн тохилог орон сууцыг хөнгөлөлттэй үнээр түрээслэх, худалдаж авах боломжтой. Тус бүсэд цэцэрлэг, сургууль, их сургууль, эрүүл мэндийн төв, спорт цогцолбор зэрэг бүхий л зүйлээр хангагдсан.

Мэдээллийн технологийн компаниудыг байрлуулах, гарааны бизнес эрхлэгчдэд ажиллах, уулзалт зохион байгуулахад зориулсан тав тухтай орчин үеийн технологиор тоноглогдсон А.С.Попов, Н.И.Лобачевын технопаркууд байрладаг. Тус паркууд нь ажлын талбай, үзэсгэлэнгийн танхим, хурлын өрөө, арга хэмжээ зохион байгуулах хурлын танхим, лекцийн танхим, 600 машины зогсоол, цахилгаан машин цэнэглэх, шуудан, банк, амралтын газар, кофе шоп зэрэг бүхий л үйлчилгээг нэг дор цогцлоосон¹⁵. Гарааны бизнес эрхлэгчдэд тав тухтай орон зай, түншүүдийн үйлчилгээ, баг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх, татварын өвөрмөц тогтолцоог санал болгодог. Тус бүсэд газрын татвар эхний 5 жил, Тээврийн зардал

¹¹ Russian Federation. (2023). Federal Law on Special Economic Zones. Moscow: Government of Russia.

¹² World Bank. (2023). The Role of Free Economic Zones in Global Trade and Investment. Washington, DC: World Bank Group.

¹³ ECD (Organisation for Economic Co-operation and Development): Дэлхийн эдийн засаг, худалдаа, хөгжлийн судалгаа.

¹⁴ <https://www.innopolis.com/en/city/history>

¹⁵ <https://sezinnopolis.ru/>

эхний 10 жил, эд хөрөнгийн татвар эхний 10 жил, өмчийн татвар 0 хувь зэргийг тус тус чөлөөлнө. Аж ахуйн нэгжүүдийн хялбаршуулсан татварын тогтолцоо үйлчилдэг.

ОХУ нь бүс нутгийн өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэдэг бөгөөд эдийн засгийн өсөлт, гадаадын хөрөнгө оруулалт татах, дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн боломжуудыг нэмэгдүүлэх болон шинэ технологийн туршилт хийхэд гол анхаарлаа хандуулж байна.

Дэлхий даяар чөлөөт бүсүүдийн тоо тасралтгүй өсөж, түүний үр нөлөөг хүртэхийн тулд үйлдвэрлэгч, хөгжүүлэгч нарт зориулсан уян хатан бодлого, зохицуулалтууд ч нэмэгдэж байна. Аль ч улсад чөлөөт бүсийг өөрийн улсын эдийн засгийг хөгжүүлэхэд түшиц болгох замаар үүсгэн байгуулж байгаа ба чөлөөт бүсийг хөгжүүлэхэд тухайн улсын төр засгаас онцгой анхаарал хандуулдаг. Чөлөөт бүсийг байгуулахад нэн түрүүнд нутаг дэвсгэрийн хувьд ашигтай байрлалыг сонгон байгуулах ба улсын бодлого, зохицуулалт зөв тууштай байх, эрх зүйн орчныг хангах, ухаалаг төлөвлөлт стратегийг боловсруулах, дэд бүтэц хангалттай, удирдах нэгжийг мэргэшсэн байдлыг харгалзан томилох шаардлагатайг чөлөөт бүсийн хөгжил өндөр түвшинд хөгжсөн орнуудаас харж болохоор байна.

Дээр дурдсан улсуудын чөлөөт бүсийн зорилго, эдийн засгийн үүрэг, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт, татварын хөнгөлөлт, удирдлагын онцлогийг нэгтгэн харуулбал:

Үзүүлэлт	БНСУ	БНХАУ	ОХУ
Зорилго	Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновац технологийн шилжилт	Экспортын үйлдвэрлэл, хөнгөлөлттэй татвар, гадаадын хөрөнгө оруулалт	Технологийн хөгжил, бүс нутгийн эдийн засгийн өсөлт
Эдийн засгийн ач холбогдол	Экспортын үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлт, гадаадын хөрөнгө оруулалт татах	Экспорт, олон улсын худалдааны төв, дэлхийн үйлдвэр	Технологийн шинэчлэлт, бүс нутгийн эдийн засгийн өсөлт
Үндсэн үйл ажиллагаа	Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бизнесийн инновац, технологийн шилжилт	Гадаад худалдаа, экспортын үйлдвэрлэл, технологийн шилжилт	Бүс нутгийн эдийн засгийн хөгжил, гадаадын хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөгжил
Хууль эрх зүйн орчин	Төрийн зохицуулалттай, өндөр хяналттай	Төрийн хяналттай, төвлөрсөн эрх зүй	Холимог хяналттай, орон нутгийн болон төвийн хяналттай
Гадаадын хөрөнгө оруулалт	Гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хөнгөлөлт үзүүлдэг	Төрийн хяналт дор гадаад хөрөнгө оруулалт татах	Татварын хөнгөлөлт, гаалийн хөнгөлөлт, хөнгөлөлттэй нөхцөл
Технологийн инновац	Технологийн хөгжил, шинжлэх ухаан, инновацыг дэмжих	Технологийн хөгжлийн шилжилт, инновац	Технологийн шилжилт, шинэ шийдлүүдийг турших, инновац
Гаалийн болон татварын хөнгөлөлт	Татварын хөнгөлөлт, гаалийн хөнгөлөлт	Гаалийн хөнгөлөлт, татварын уян хатан зохицуулалт	Татварын хөнгөлөлт, гаалийн хөнгөлөлт
Удирдлага	Орон нутгийн засаг, төрийн хяналт	Төрийн зохицуулалт, төвлөрсөн удирдлага	Орон нутгийн засаг, төвлөрсөн хяналт

Эдгээр бүсүүд нь тухайн улс орны эдийн засгийг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, экспортын үйлдвэрлэл болон технологийн шилжилт хийх гол хэрэгсэл болж ажиллаж байна¹⁶. БНСУ, БНХАУ, ОХУ-ын чөлөөт бүсүүдийн онцлогийг харгалзан үзэхэд эдгээр бүсүүд нь эдийн засгийн өсөлт, экспорт, инновац, технологийн шилжилт зэрэг чиглэлээр ялгаатай боловч нийтлэг зорилго нь улс орны эдийн засгийг олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай болгох, инновац, технологийн хөгжлийг дэмжих, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэдэг.

Дүгнэлт

Олон улсын чөлөөт бүс хурдацтай хөгжсөн гол хүчин зүйлүүдийн нэг нь бизнес эрхлэгчдийн анхаарлыг татсан, хөрөнгө оруулалт татах боломжтой, худалдаа үйлдвэрлэл эрхлэхэд таатай ашигтай байрлал юм. Тиймээс улс орны хөгжлийн хурдасгахын тулд чөлөөт бүсүүдийн ач холбогдлыг ойлгох, чөлөөт бүсийг хөгжүүлэхдээ байрлал, оновчтой төлөвлөлт, хууль эрх зүйн уян хатан зохицуулалт, мэргэшлийн удирдлагын тогтолцоонд анхаарлаа хандуулах нь улс орнуудын эдийн засгийн гол стратегийн нэг болоод байна.

Нөгөө талаар орчин үеийн техник технологийн хөгжлийг даган мэдээллийн технологи, хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг хотууд бий болж байгаа нь чөлөөт бүсүүдийг дараагийн түвшинд гарахыг шаардаж байна.

Энэ цаг үед Монгол Улсын чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг дээрх улсуудыг сайн туршлагад үндэслэн чөлөөт бүсийг хөгжүүлэх төрийн зохицуулалт, хөрөнгө оруулалтын урамшуулал, дэд бүтцийн шийдэл зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай бөгөөд газар зүйн байршил, дэд бүтэц, татварын уян хатан бодлого, төрийн зохицуулалтын ач холбогдлыг судлан, оновчтой төлөвлөлт хийх арга зүйг боловсруулах төрийн зохицуулалт, хөрөнгө оруулалтын урамшуулал, дэд бүтцийн шийдэл зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай байна.

¹⁶ ECD (Organisation for Economic Co-operation and Development): Дэлхийн эдийн засаг, худалдаа, хөгжлийн судалгаа.

Ашигласан материал

1. Чөлөөт бүсийн тухай хууль (2015)
2. Гаалийн бүрдүүлэлтийг нэг мөр болгох тухай конвенц (1973)
3. Монгол Улсын Их Хурлын тогтоол (1995) №87
4. World Bank. (2023). The Role of Free Economic Zones in Global Trade and Investment. Washington, DC: World Bank Group
5. Government of South Korea. (2023). Free Economic Zones Act. Ministry of Trade, Industry, and Energy.
6. Government of South Korea. (2023). Free Economic Zones Act. Ministry of Trade, Industry, and Energy
7. World Bank. (2023). The Role of Free Economic Zones in Global Trade and Investment. Washington, DC: World Bank Group
8. Chinese Ministry of Commerce. (2023). Development of Free Trade Zones in China: Policies and Impact. Beijing: Commerce Press.
9. World Bank. (2023). The Role of Free Economic Zones in Global Trade and Investment. Washington, DC: World Bank Group.
10. Russian Federation. (2023). Federal Law on Special Economic Zones. Moscow: Government of Russia.
11. World Bank. (2023). The Role of Free Economic Zones in Global Trade and Investment. Washington, DC: World Bank Group.
12. World Bank. (2023). The Role of Free Economic Zones in Global Trade and Investment. Washington, DC: World Bank Group.

Цахим эх сурвалж

1. www.ifez.go.kr
2. www.gov.cn
3. www.state.gov
4. www.shftz.pudong.gov.cn
5. www.innopolis.com
6. www.sezinnopolis.ru
7. <https://zfz.gov.mn/>